

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН “САРЫН МЭДЭЭ”

Барилга, хот байгуулалтын хэлтэс:


1. Барилга угсралт, авто замын 6 ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Шивээговь сумын 6,9км авто замын ажил – 30%
- Шивээговь сум 320 хүүхдийн сургуулийн барилга -45%
- Сүмбэр сум,Ахмадын өргөөний барилга - 40%
- 5-р сургуулийн өргөтгөлийн барилга – 25%
- Усан бассейн бүхий Спорт цогцолборын барилга -10%
- 6-р цэцэрлэгийн 120 ортой цэцэрлэгийн өргөтгөлийн барилга – Ажил эхлээгүй

Ахмадын өргөөний барилга



Шивээговь сумын 6,9км авто зам



Шивээговь сум, 320 хүүхдийн сургуулийн барилга



5-р сургуулийн өргөтгөлийн барилга



Усан бассейн бүхий Спорт цогцолборын барилга



2. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа нийт 4 ажлын бетон зуурмагийн шинжилгээний дээжийг авч, бетоны бэхжилтийг 7, 28 хоногт Барилгын хөгжлийн төвийн лабораторитой хамтран шинжилгээнд хамруулан ажиллаж байна.



3. “Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм”, “Барилгын хувийн хэрэг хөтлөх журам”-ын хүрээнд төрийн байгууллагуудын хувийн хэрэг хөтлөлтөд үзлэг шалгалт, бүртгэл хийх, хувийн хэргийг цахимжуулах, барилгын ашиглалтын дүрмийг ашиглагч байгууллага нарт танилцуулах ажлыг 14 байгууллагад зохион байгуулж, гарын авлага материалыг тарааж, тухайн барилгад авах шаардлагатай байгаа арга хэмжээнд санал солилцон, зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан.



4. Барилга байгууламжид ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг нийт 17 объектод олгосон, байнгын ашиглалтад оруулах ажлын хүрээнд Орон нутгийн Өмчийн орон сууцуудын байрны засварын ажил, Сүмбэр сумын 2-р сургуулийн дотуур байрны засварын ажилд улсын комисс ажилласан.

2024.09.20-ний өдөр Монгол улсад Статистикийн алба үүсэж, бэхэжсэний 100 жилийн ойн хүрээнд иргэдэд зориулсан “Нээлттэй хаалганы өдөрлөг”- т байгууллагын албан хаагчид иргэдэд өөрийн байгууллагын үйл ажиллагааг танилцуулан оролцсон.

